

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Номын сангийн уншигчаар хэрхэн бүртгүүлэх вэ?

МУИС-ийн үнэмлэх /магистр, доктор/ ашиглан номын сангийн уншигчаар бүртгүүлж үйлчилгээ авна. Номын сангийн систем нь МУИС-ийн удирдлагын Сиси мэдээллийн системээс таны мэдээллийг автоматаар татаж авах бөгөөд суралцагч та “Идэвхтэй сурч байгаа” төлөвт байх шаардлагатай.



Электрон каталоги - <http://catalog.num.edu.mn>

МУИС-ийн номын сангийн электрон каталогид цаасан болон цахим материалын мэдээллийг каталогжуулан оруулсан. Уншигч та <http://catalog.num.edu.mn> хаягаар хандан сургалт судалгаанд ашиглагдах ном, хэвлэлийн бүтээгдэхүүн номын санд байгаа эсэх, аль уншлагын заалнаас захиалан авах боломжтой, захиалгад гарсан, уншлаганд бэлэн байгаа талаарх мэдээллийг авах боломжтой.

Үйлчлүүлэх номын сан, уншлагын танхим

НЭГЖ, САЛБАР	БАЙРЛАЛ	ТАЙЛБАР
Эрдэм шинжилгээ, гадаад номын уншлагын танхим	Номын сан №411	3 хувьтай номын 3-5 хоног, 4-с дээш хувьтай номыг 7 хоногийн хугацаатайгаар гэрээр олгоно. /Номын хугацаагаа сунгуулах боломжтой./ Жич: Нэг хувь байдаг ном, диссертаци, магистрын дипломын ажлыг уншлагын танхимаар сууж үзнэ.
Тогтмол хэвлэлийн уншлагын танхим	Номын сан №108	Тогтмол хэвлэл нь нэг хувь тул зөвхөн уншлагын танхимаар сууж үзнэ.
БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН НОМЫН САН		
БС-ийн номын сан	Хичээлийн 5-р байр №505	3 хүртэлх номыг 1-3 хоногийн хугацаатайгаар гэрээр олгоно.
ОУХНУС-ийн номын сан	Хичээлийн 5-р байр №304	
ХЗС-ийн номын сан	Хичээлийн 3-р байр №205	


Цахим ном, сэтгүүлийг хэрхэн унших вэ?

- Номын сангийн электрон каталогийн <http://catalog.num.edu.mn> хаягаар орно.
- Номын сангийн уншигчаар бүртгүүлсэн бол өөрийн эрхээрээ нэвтэрч орно.
- Ахисан түвшний хайлтын хэсгээс цахим материалын төрлөө сонгож хайх утгаа оруулна.
 - Цахим ном
 - Е-магистрын ажил
 - Цахим сэтгүүл

- Хайлтын үр дүнд гарч ирсэн цахим материал дээр дарж “Онлайнаар үзэх” товчин дээр дарж цахим материалыг үзэх боломжтой.

Цахим материал хэрхэн унших талаар видео гарын авлагыг номын сангийн веб хуудасны тусламж, зөвлөгөө хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

https://library.num.edu.mn/?page_id=4150



Эрдэм шинжилгээний уншлагын танхимаас онлайнаар ном хэрхэн захиалах вэ?

- Магистрантаас дээш төвшний уншигч онлайнаар ном захиалах боломжтой.
- Зөвхөн Эрдэм шинжилгээний фондоос ном захиална.
- Нэг удаа 4 ширхэг ном захиалах боломжтой.
- Захиалга өгсөн мөчөөс эхлэн 24 цагийн дотор захиалсан номоо Номын сангийн №412 тоотод ирж авахгүй бол таны захиалга цуцлагдах болно.
- Та захиалсан номоо ирж авахдаа МУИС-ийн үнэмлэх, уншигчийн карттайгаа ирнэ үү.

Номоо онлайнаар хэрхэн захиалах талаар видео гарын авлагыг номын сангийн веб хуудасны тусламж, зөвлөгөө хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

https://library.num.edu.mn/?page_id=4150

Өөртөө үйлчлэх хэвлэх, хувилах үйлчилгээ



- МУИС-ийн үнэмлэхээ “Номын сангийн нэг цэгийн үйлчилгээ №107” нь дээр цэнэглүүлнэ. Хамгийн ихдээ 5000 төгрөгөөр цэнэглэх боломжтой.
- Өөртөө үйлчлэх төхөөрөмжид оюутны үнэмлэхийг хийж хэвлэх, хувилах команд өгнө. /1 нүүр материал хувилж, хэвлэхэд 50 төгрөг/
Жич: Хэвлэх, хувилах үйлчилгээ явагдаж байх үед оюутны үнэмлэхээ сугалах болон хөндийрүүлэхгүй байхыг анхаарна уу!



Номын сангийн мэдээ, мэдээллийг хаанаас авах вэ?

МУИС-ийн номын сан нь бие даасан цахим хуудас

<http://library.num.edu.mn> болон [facebook.com/NUMLibrary](https://www.facebook.com/NUMLibrary) фэйсбүүк хуудсаар дамжуулан номын сантай холбоотой мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэж байна.



Магистр, докторын судалгааны бүтээлийг номын санд хураалгахад тавигдах шаардлага

Цаасан хэлбэр

Хэвлэмэл хэлбэрээр магистр, докторын судалгааны бүтээлийг номын санд хүлээлгэн өгөхдөө дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- **Магистрын судалгааны бүтээлийг тухайн салбар сургуулиас баталсан загвар, шаардлагын дагуу бичиж, ном хэлбэртэй хэвлүүлсэн байх;**
- Докторын судалгааны бүтээлийг “Докторын диссертацийн эх бэлтгэх, хэвлүүлэх, диссертаци, судалгааны үр дүнг хүлээлгэн өгөхөд баримтлах журам”-ын 3-т зааснаар бичиж, ном хэлбэртэй хэвлүүлсэн байх;
- Судалгааны бүтээл нь удирдагч болон шүүмжлэгчийн гарын үсгээр баталгаажуулсан, сүүлийн хувилбар байх.
- Эрдэм шинжилгээний ажлын номзүйн бичилтэнд тавигдах стандартын дагуу дараах мэдээллийг бүрэн оруулсан байх.
 - Индекс /мэргэжлийн, мэргэшлийн/
 - Удирдагч, зөвлөх, шүүмжлэгийн овог, нэр, зэрэг, цол
- Судалгааны бүтээлийн сүүлийн хуудсанд хавсралт №1 тусгасан загварын дагуу мэдээллийг бөглөсөн байх.

Цахим хэлбэр

Цахим хэлбэрээр /CD, DVD/ магистр, докторын судалгааны бүтээлийг номын санд хүлээлгэн өгөхдөө дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Үндсэн судалгааны бүтээл болон хураангуй нь текстэн “PDF” хэлбэрийн тус тусдаа файл байх;
- Цахим болон цаасан хэлбэрээр хэвлэгдсэн судалгааны ажил нь үг үсэг, өгүүлбэр, утга, агуулга болон хуудасны дугаарлалт зөрүүгүй байх;
- Үсгийн фонд нь танигдаж байх;
- Дипломын хавтас, нүүр хуудсан дээрхи мэдээллийг бүрэн багтаасан хаягийг хэвлэн CD дээр нааж, зориулалтын хатуу хайрцаганд хийн номын санд хүлээлгэн өгөх.



**МУИС-ийн номын санд магистр, докторын судалгааны бүтээл
хүлээн авах хуудас**

..... он сар өдөр

Холбоо барих мэдээлэл:

Овог: Нэр:.....

Утас: Цахим шуудан:

Бүтээлийн нэр /монгол хэл дээр/
.....
.....
.....

Товч агуулга /монгол хэл дээр/
.....
.....
.....

Түлхүүр үг /3-аас дээш/
.....
.....
.....

Хамгаалсан он сарөдөр

Хамгаалсан хот, газар

Бүтээлийг хүлээлгэн өгсөн байгууллага, номын сангийн нэр /МУИС-ийн номын сангаас бусад/
.....
.....
.....

Бүтээлийг МУИС-ийн номын санд хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авч фонд
бүрдүүлэн, уншлага үйлчилгээнд ашиглана.

Танилцаж зөвшөөрсөн:/ /

Хүлээн авсан номын санч:/ /